



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1997 оны 01 дугаар
сарын 18 өдөр

Дугаар 5/18

Улаанбаатар
хот


Нийслэлийн хэрэгжүүлэгч агентлагуудыг байгуулах тухай

Нэг. Монгол улсын Засгийн газрын 1996 оны 263 дугаар тогтоолыг үндэслэн нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй дор дурдсан хэрэгжүүлэгч агентлагуудыг ажиллуулж, орон тооны хязгаарыг хавсралтаар баталсугай.

1. Хотын өмчийн газар
2. Цагдаагийн газар
3. Татварын газар
4. Нийгмийн даатгалын газар
5. Байгаль орчны хяналтын газар
6. Боловсролын газар
7. Эрүүл мэндийн газар
8. Нийтлэг үйлчилгээний газар
9. Гаалийн газар
10. Газрын харилцаа, хөрөнгийн бүртгэлийн алба
11. Санхүүгийн хяналт шалгалтын алба
12. Статистик, мэдээлэл, судалгааны алба
13. Соёлын газар
14. Биеийн тамир, спортын хороо
15. Хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн газар

Хоёр. Дээрхи хэрэгжүүлэгч агентлагуудын дүрмийг шинэчлэн боловсруулж, удирдлага, бүтэц зохион байгуулалтын асуудлыг 1997 оны 1 дүгээр сард багтаан шийдвэрлүүлэхийг Тамгын газар (н.Болдсайхан)–т даалгасугай.

Гурав. Захирагчийн ажлын алба болон түүний дэргэдэх хэрэгжүүлэгч агентлагуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсруулж 1997 оны 1 дүгээр сард багтаан Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хуралд оруулахыг хотын Ерөнхий менежер (н.Бямбаа)–т үүрэг болгосугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.НАРАНЦАЦРАЛТ



ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТ-ЛАГУУДЫН ОРОН ТООНЫ ХЯЗГААР

д/д	Хэрэгжүүлэгч агентлаг	Орон тооны хязгаар
1.	Өмчийн газар	35 хүртэл
2.	Цагдаагийн газар	130 хүртэл
3.	Байгаль орчны хяналтын газар	43 хүртэл
4.	Боловсролын газар	23 хүртэл
5.	Эрүүл мэндийн газар	16 хүртэл
6.	Газрын харилцаа, хөрөнгийн бүртгэлийн алба	40 хүртэл
7.	Санхүүгийн хяналтын алба	20 хүртэл
8.	Статистик мэдээлэл, судалгааны алба	16 хүртэл
9.	Соёлын газар	6 хүртэл
10.	Биеийн тамир спортын хороо	5 хүртэл
11.	Хүүхэд залуучууд, эмэгтэйчүүдийн газар	11 хүртэл
	ДҮН	345

Тайлбар: Нийтлэг үйлчилгээний газрыг Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн үүрэг гүйцэтгэгчийн 1997 оны Б/14 захирамжаар байгуулсан.

Хотын татварын газар, Гаалийн газар, Нийгмийн даатгалын газрын бүтэц, орон тооны хязгаарыг ерөнхий газар нь тогтоосон учир энд оруулаагүй болно.